

МОНГОЛД ЖУУЛЧИЛСАН ХҮМҮҮСИЙН АРВАН ТОМ ТЭМДЭГЛЭЛ

Д.ЗОРИГТ*

“Өвөр монголын өдрийн сонин”-д Монголд жуулчилсан хүмүүсийн бичиж үлдээсэн томоохонд тооцогдох арван номын тухай материал нийтлэгдсэнийг гол агуулгаар нь танилцуулвал :

1. “Монгол-татаарын тухай бүрэн тэмдэглэл” нь 1221 онд Сүн улсын элч Жао Хун монгол нутагт жуулчлахдаа үзэж сонссоноо тэмдэглэсэн бүтээл юм. Үүнд монголын эзэн хаан, цэргийн жанжнуудын тухай болон дайн байлдааны урлаг, зэр зэвсэг, монголчуудын зан заншил, сүсэг бишрэл, хурим найрын ёс дэг зэргийн талаар дурдсан байдаг. Энэ номыг Мөнхзаяа монголчлон Хармөрөн мужийн хэвлэлийн хорооноос 1979 онд хэвлэн гаргасан байна.

2. “Хар татаарын тухай хэргийн товч” нь 1237 онд өмнөд Сүн улсын элч Фэн Дэя, Сюй Тин нар монгол нутагт аялан явахдаа монголын улс төр, эдийн засаг, соёл, цэргийн хэрэг болон зан заншлын талаар үзэж мэдсэнээ тэмдэглэсэн ном юм. Энэхүү ном нь тухайн асуудлуудыг маш нарийн тэмдэглэснээрээ дээр дурдсан “Монгол-татаарын бүрэн тэмдэглэл”-ээс ялгарах аж. Уг номыг Мөнхзаяа монголчлон Хар мөрөн мужийн хэвлэлийн хороонд хэвлүүлжээ.

3. “Марко Пологийн жуулчлалын тэмдэглэл” нь Италийн худалдаачин язгууртны хүү Марко Поло Юань улсын төрд 1275-1292 онд нийт арван долоон жил алба хашаад буцсаныхаа дараа шоронд байх хугацаандаа ярьж тэмдэглүүлсэн бүтээл гэдэг бөгөөд тэр цагаас хойш өнөөдрийг хүртэл дэлхий дахинд гайхагдсаар байгаа билээ. Уг бүтээлийг Гэрэлцогт Японы эрдэмтэн Аоки Кацио-гийн орчин цагийн япон хэл рүү орчуулсан эхийг баримтлан монголчилж, 1978 онд Хар мөрөн мужийн хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн байна.

4. “Плано Карпиний жуулчлалын тэмдэглэл”-ийн уг нэр нь “Монголын түүх” юм. Плано Карпин 13 дугаар зууны дөчөөд онд /1245-1247/ монголын хаант улсад элчээр ирж, монголын их хааны хаан ширээнд суух баяр ёслолд оролцсон анхны европ хүн болно. Тэрээр тухайн цаг үеийн монголын нийгмийн амьдралын бүх талыг, ялангуяа цэрэг дайны байдлыг нарийн ажиглаж, үнэн бодитой тэмдэглэл үлдээсэн хүн юм. Энэ бүтээлийг мөн Гэрэлцогт орос, япон хэлээрхи эхийг үндэслэн монголчилж, 1983 онд Өвөр монголын хэвлэлийн хорооноос хэвлэн гаргасан байна.

5. “Ульям Рубрукийн жуулчлалын тэмдэглэл”-ийн уг нэр нь “Дорно дахины улс орнуудаар жуулчилсан тэмдэглэл” бөгөөд Рубрук 13 дугаар зууны дунд үеэр /1253-1255/ монголд шашны элчээр ирээд бичсэн бүтээл юм. Энэ номыг Гэрэлцогт монголчилж, 1983 онд дээр дурдсан номтой нийлүүлэн Пал Карпини, Ульям Рубрукийн “Монголд жуулчилсан тэмдэглэл” нэртэйгээр хэвлүүлжээ.

6. “Чан Чун Бумбын баруун зүгт зорчсон тэмдэглэл” номыг Чан Чун Бумбын итгэлт шавь Ли Жичан туурвин бичжээ. Тэрээр багшаа дагаж монголоор дайран Дундад Азид очиж, Чингис хаантай уулзсан хийгээд зам зуур үзэж сонссон зүйлээ нарийн тэмдэглэсэн нь ихээхэн үнэтэй бүтээл болсон байна. Энэ ном 1228 онд бичигдсэн гэдэг. Энэхүү ховор нандин дурсгалт бичгийг хоёр ч хүн тус тусдаа орчуулан хэвлүүлсний нэгэнд хоёр чухал материал дагалдуулан орчуулсныг онцгойлон дурдууштай. Үүнд “Чан Чун Бумбын баруун зүгт зорчсон тэмдэглэл”-д Чингис хаан Чан Чун Бумба нарын ярианы агуулгыг нууцлахын үүднээс тэмдэглээгүй бөгөөд энэ хэсгийг “Бумбын

*Д.Зоригт. ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

суртахууны ганжуур”-аас олж орчуулсан нь тун сайшаалтай юм. Нөгөө нь Елюй Чуцайн зохиосон “Баруун зүгт аялсан тэмдэглэл” юм. Елюй Чуцай Чингис хааныг дагаж баруун зүгт аялж ирээд энэхүү зохиолоо туурвижээ. Уг ном 1228-1229 оны үед зохиогдсон бололтой. Өвөр монголын Боловсролын хэвлэлийн хорооноос энэхүү үнэт бүтээлийг 1993 онд хэвлүүлсэн байна.

7. “Жан Дэхуйн давааны араар жуулчилсан тэмдэглэл” нь Алтан улсын түшмэл Жан Дэхуй 1247-1248 онд нэг жилийн хугацаанд монгол орноор жуулчилж, өөрийн үзэж сонссоноо тэмдэглэсэн бүтээл болно. Энэ номыг “Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан” сэтгүүлийн редактор Эрдэмт монголчлон 1994 онд ӨЗО-ны Боловсролын хэвлэлийн хорооноос хэвлүүлжээ. Энэхүү тэмдэглэл нь тухайн үеийн монголчуудын ахуй амьдрал, зан заншил болон газар нутгийн байдал, Хубилай сэцэн хааны залуу үеийн үзэл санааг ойлгоход туслах нэн үнэт ховор материал юм.

8. “Калавиогийн зүүн тийш элчилсэн тэмдэглэл” нь 15 дугаар зууны үеэр Испаний нэгэн элч вангийнхаа зарлигаар Төмөр хаанд бараалхан золгохоор явахдаа бичсэн аялалын тэмдэглэл юм. Үүнд Төмөрийн хаант улсын улс төр, эдийн засаг, гадаад харилцаа, соёл боловсрол, цэргийн явдал хийгээд Төмөрийн хувь хүний зан чанар, бодол санаа, гэр бүлийн амьдрал зэргийг нарийн дүрсэлсэн нь монгол судлалын ажилд ихээхэн ач холбогдолтой юм. Энэ номыг Батжаргал хятад хэлний орчуулгыг нь үндэслэн монголчилж, 1994 онд Үндэстний хэвлэлийн хорооноос хэвлүүлжээ.

9. “Монгол зан суртахууны тэмдэглэл” бол Мин улсын түшмэл Сяо Даньхэн 17 дугаар зууны эхээр бүгдийг захирагч сайдын тушаалд байхдаа тэр үеийн Хөххотын Түмэдийн монголчуудын байдлыг үзэж сонссоноо тэмдэглэн авч, найруулан бичсэн нь юм. Энэ ном 20 бүлэгтэй бөгөөд тэр үеийн Түмэд, Ордосын монголчуудын ахуй

амьдралыг бүх талаар, бас зарим зүйлийг нэлээд нарийн тодорхой тэмдэглэсэн тул тэр үеийн монголчуудын мал аж ахуй, газар тариалан, ан гөрөө, гар үйлдвэр, худалдаа арилжаа, шашин шүтлэг, соёл боловсрол, хууль цааз, зан заншил зэргийг судлахад нэн чухал бүтээл болжээ. Энэхүү номыг хорчины Асралт монголчилж, 1979 онд Өвөр монголын Ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн байна.

10. “Монгол ба Тангуд” нь Оросын алдарт жуулчин Николай Михайлович Прежевальский Монгол ба Хөх нуур, Түвдийн өндөрлөгөөр судалгааны ажил хийж туурвисан бүтээл юм. Тэрээр 1871 онд хаант Оросын Газар зүйн нийгэмлэг болон хуурай замын цэргийн эрх баригчдын томиллолтоор Монгол, Ганьсу, Хөх нуур болон Түвдийн хойт хэсгээр гурван жил гаруй явж, газар зүй, уур амьсгал, амьтан, ургамал, угсаатны зүйн зэрэг чиглэлээр нарийн судалгаа хийж, ихээхэн материал сэлт цуглуулан, нарийвчилсан газрын зураг үйлдсэн байна. Эдгээр нь Монгол болон Хөх нуур, Түвдийн өндөрлөгийн байгаль орчныг судлах, ялангуяа Цин улсын сүүлийн үе дэх Монгол, Түвдийн нийгэм, түүх, үндэстэн, угсаатны байдал, эдийн засаг, шашин шүтлэг, зан заншил зэргийг судлахад олдошгүй ховор нандин материал юм.

Дээр дурдсан арван тэмдэглэл нь эдүгээ хүртэл уйгаржин монгол бичгээр орчуулагдаад байгаа болно. Үүнээс гадна гадаад хэлнээс орчуулагдаагүй буюу хятад хэлээр орчуулагдсан тэмдэглэлүүд нэлээд байх нь дамжиггүй юм. Эдгээрээс Францын элчийн “Монгол Түвдээр аялсан тэмдэглэл” /1841-1846/, Оросын жуулчны “Гадаад Байгалийн орноор аялсан тэмдэглэл” /1844/, Оросын элчийн “Дундад улсад зорчсон тэмдэглэл” /1692-1695/ зэрэг ном хятад хэлээр хэвлэгдсэн байна.